

УУЛБАЯН СУМЫН 10 САРЫН МЭДЭЭ

2024-10-29

Зүүнбулаг

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:

д/д	Шинээр төрсөн	Нас барсан	Эцэг, эх тогтоосон	Гэрлэсэн	ИҮНэмлэх 16 шинэ	25, 45 сунгалт	Ши/хөдөлгөөн			ИҮ-ийн лавлагаа	Тө/Гэр дахин
							Аймаг нийслэл	Сум, дүүргээ	Баг, хороон		
1	32 /эр-16/	15 /эр-8/	2/эр-1/	3	20 /эр-14/	32 /эр-16/	17	10	7	126	6

д/д	Хуулийн этгээд	Тоон гарын үсэг олголт			
	Шинээр байгуулагдсан хоршоо	Нийт	Иргэний үнэмлэхээр	Утасны аппаар	Эр
1	10	472	318	154	220

Нийгмийн даатгалын ерөнхий газраас 09 дүгээр сарыг “Нээлттэй мэдээллийн сар” болгон зарласантай холбогдуулан нийгмийн даатгалын газраас аяны төлөвлөгөө гарсан.

Энэхүү аяны хүрээнд нийгмийн даатгалын хуульд орсон өөрчлөлт, цахим нийгмийн даатгал чиглэлээр Төрийн банктай хамтарч нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгууллаа.

Өдөрлөгийн үеэр мэдээллийг нийт 43 иргэнд хүргэж, гар утасны апплекшиныг -18, сайн дурын даатгалд -5 даатгуулагчийг хамруулсан.





Явуулын үйлчилгээг Дэлгэр багийн малчдын хотонд 12 өрхийн 38 иргэнд, Эмийн сан, Халуун ус, үсчин, дэлгүүр, нийт 56 даатгуулагчдад сурталчилгаа хийж гарын авлага 98 олгож гар утасны апплекшиныг 24 иргэний утсанд суулгаж, ашиглах заавар зөвлөгөө өгч сайн дурын даатгал -2 малчныг хамрууллаа.

Сайн дурын даатгуулагчдын даатгалаа хэрхэн төлөх талаар заавар, зөвлөмж бэлтгэн сумын нийгмийн даатгалын болон бусад группээр тогтмол мэдээлж байна.

Цахимаар нийгмийн даатгалын шимтгэлээ хэрхэн төлөх, төлөх хугацааг сануулах зорилгоор цахим мэдээлэл бэлтгэн сумын нийгмийн даатгалын групп болон бусад 5 группэд байршууллаа.



Нийгмийн даатгал газраас "НЭГ АЖИЛТАН НЭГ 7 ХОНОГТ НЭГ ШИНЭ ДААТГУУЛАГЧ" аяныг 10 дугаар сарын 15 -с 11 дүгээр сарын 15 хүртэл зарласнаар шинээр 2 даатгуулагчийг сайн дурын даатгалд хамруулаад байна.

Хамрагдалт, шимтгэлийн өр авлагын талаар

1. 2024 оны 09 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар шинээр 2 аж ахуй нэгж хамруулж 22 ажил олгогчийг нийгмийн даатгалд :

518369.6 мян төг шимтгэлийн орлого орохоос 747994,3 мян төгрөгийн шимтгэл орж 144,3%

Сайн дурын даатгалд :

ХХЭ сайн дурын даатгалд 50 даатгуулагч даатгуулахаас-20 даатгуулагч

СДД эх 30 даатгуулахаас -28 даатгуулагч даатгаж

СДД малчин -119 даатгуулахаас-110 даатгуулагч

Хүүхдээ асарч байгаа эх / эцэг / 8 даатгуулахаас - 8 -г тус , тус даатгуулсан байна.

2. 2023 онд 1 байгууллагын 844,2мян төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлагатай гарсан. Тус байгууллагын өр авлагыг шүүхэд шилжүүлсэнээр өр авлага бүрэн барагдсан.

3.Өр авлагатай аж ахуй нэгжийн удирлага, нягтлангуудтай уулзаж зөвлөж ярилцсаны үр дүнд 2024 оны 08 дугаар сарын тайлангаар “ЭМ ЭЛ ЦАХИУРТ ОВОО” ХХК нь 66935.6 мян .төг өр авлагатай байсныг “Улсын байцаагчийн албан шаардлага” хүргүүлснээр 36941,0 төгрөг, он гарсаар шимтгэлээ огт хийгээгүй “Хонгор байшинт” ХХК -ны ХААН банкн дах дансыг хааж 964,0 мян төгрөгийн авлагыг тус тус барагдууллаа. Мөн “Рашааны тунгаамал, Үхэр уяа” ХХК-д сануулах арга хэмжээ авснаар өр авлага бүрэн барагдсан.

2024оны 01 сарын 01 нээс дараах өргөдлийг хүлээн авч бүрэн шийдвэрлээд байна.

Улсын байцаагчид ирсэн өргөдөл-63, үүнээс						
Тэтгэвэр тогтоолгох	Өөрчлөн тогтоолгох	Банк солих	Тэтгэ мж	Ажилгүйдл ын тэтгэмж	Шийдвэрлэсэн	Үйлчилгээ авсан иргэн
20	21	4	12	6	63	412



- Хими биологийн багш Ж.Нэргүй захирлын түр орлон гүйцэтгэгчээр 10 сарын 02-ны өдөр томилогдов.

Дэлхийн болон Монголын багш нарын өдрөөр сургалтын менежер Д.Уугансүрэн “Боловсролын тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр, бага ангийн багш Э.Түмэнжаргал Боловсролын Яамны “Жуух бичиг”-ээр шагнагдлаа.



10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн суралцагчдын дархлааг дэмжих зорилгоор “Өдөр бүр сүү” аяны хүрээнд эцэг эх, асран хамгаалагчдын зүгээс ангиудад долоо хоногт 2 удаа буцалгасан сүү, аарц, витамин өгч байна.



Сургалтын менежер Д.Уугансүрэн тус сургуулийн 31 төрлийн статистик мэдээг гаргаж Боловсролын мэдээллийн системд шивж оруулав. 2024.10.01-10.25

- Аймгийн Нийгмийн даатгалын газраас санаачлан Төрийн сангийн хэлтэс, Татварын газар хамтран зохион байгуулсан Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх, ажил олгогч даатгуулагчдыг санхүүгийн эрсдлээс хамгаалах, шинэчлэн батлагдсан нийгмийн даатгалын хууль, тогтоомжийн хэрэгжилтийн талаар эрх зүйн мэдлэг олгох сургалтад захирлын албыг түр орлон гүйцэтгэгч Ж.Нэргүй, нягтлан бодогч Д.Доржпагма нар хамрагдсан. 2024.10.24
- Аймгийн нийтийн номын сангаас зохион байгуулдаг “Судар эгшиглэн 2024” уншигчдын уралдаанд нийт 3а, 3б ангиуд багш-1, хувь сурагч-1 номын тэмдэглэлийг хугацаанд нь хүргүүлсэн.



- 6-9 дүгээр ангийн сурагчдад 2022-2024 оны түрээсийн нийт 192 багц сурах бичгийг түрээслүүлж 4,285,500 төгрөгийг түрээсийн сурах бичиг эргэлтийн сангийн дандсанд шилжүүлэв. 2024.10.25
- Сумын нэгдсэн халаалтанд 10 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн холбогдож халаалт авсан.

СОЁЛЫН ТӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР:

1.1 Ахмад настны баярыг тэмдэглэн өнгөрүүлэх шийдвэрийг НҮБ-аас 1990 онд гаргасан бөгөөд Монгол улс 1992 оноос эхлэн тэмдэглэжээ. Үүний хүрээнд: 10 дугаар сарын 01 өдөр Ахмадын баярыг тохиолдуулан хүндэтгэлийн тоглолтыг зохион байгууллаа. Тоглолтод насанд хүрэгч 7, хүүхэд 15 оролцлоо. (Зураг1)

1.2 10 дугаар сарын 02 өдөр Ахмадуудад зориулан Ахмадын баяр-2024 Хөтөлбөрт үдшийн цэнгүүн зохион байгуулсан. Нийт 78 ахмад оролцлоо. (Зураг2)

1.3 СӨБ, Эцэг эхийн зөвлөлтэй хамтран 10 сарын 18-нд Хүүхдийн дууны караоке тэмцээн зохион байгуулсан. Нийт 6 багийн 24 оролцогч оролцлоо. (Зураг3)

1.4 Эцэг эхчүүдэд зориулсан Хөтөлбөрт үдшийн цэнгүүн зохион явууллаа. Үдшийн цэнгүүнд 13 оролцогч ая дуугаа өргөн оролцлоо. Нийт 89 иргэд хамрагдлаа. (Зураг4)

1.5 Чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, соёлын боловсрол олгох, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах зорилгоор: 10 дугаар сарын 01-с эхлэн 7 хоног бүрийн 3дах өдөр ахмадуудад стандарт 16 бүжгийн сургалт явагдаж байна. Сургалтыг Ахмад багш Д.Буд, Ж.Болормаа нар удирдан явуулж байна.(Зураг5)

СОЁЛЫН ӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР:

4.1 Ахмадын холбоотой хамтран сумдын уялдаа холбоог идэвхжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, нумт харвааг хойч үедээ өвлөн уламжлуулах, сурталчилах зорилгоор:Мөнххаан, Түвшинширээ, Баяндэлгэр сумдадтай хамтран Ахмадын Нумт харвааг зохион байгууллаа.(Зураг6)

СОЁЛЫН ОЛОН ТАЛТ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР:

6.1 Бүх нийтийн соёл, урлагийн боловсролын хөтөлбөрийн хүрээнд: "Жаахан шарга" театрын бүтээл МУСТА З.Далайгийн найруулга "Домгийн хатираа" этник концерт, Гэгээн муза наадмын хүүхдийн шилдэг бүтээл С.Маршакын "Муурын байшин" мюзикл аялан тоглолт 10 дугаар сарын 17 нд тоглогдлоо. Нийт 287 хүүхэд, 68 иргэд үзсэн байна. (Зураг7)

БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА:

7.1 Ардчилсан намын Орон нутгийн сонгуулийн сурталчилгааны нээлтийн үйл ажиллагаа 09 сарын 27 өдөр боллоо. (Зураг8)

7.2 09 сарын 28 өдөр МАН-ын Орон нутгийн сонгуулийн сурталчилгааны нээлтийн арга хэмжээ боллоо.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР:

- Үзлэг бүгд- 2927
- Амбулаторын үзлэг- 1342
- Урьдчилан сэргийлэх үзлэг – 943
- Гэрийн дуудлага – 566
- Алсын дуудлага- 196
- Хэвтэн эмчлүүлэгч – 190 0-15 насны хүүхэд- 55
- Өдрийн эмчилгээ – 34
- Лабораторийн шинжилгээ- 283 33 19 18 16 9 4 84 100
- Халдварт бус өвчин үзлэг (чихрийн шижин, артерын даралт)- 450

- Эмэгтэйчүүдийн эсийн шинжилгээ – 54
- 0-2 насны 22 хүүхдийг товлот дорхлаажуулалтанд бүрэн хамруулсан байна.
- 0- Тумуугийн эсрэг дархлаажуулалт - 190
- Идэвхитэй хяналт – 76
- Сургалтад хамрагдсан иргэд – 378
- Тараах материал – 280
- Цахим орчинд байршуулсан мэдээлэл – 25

1. Олон улсын ахмадын баярыг угтан сумын ахмадын холбооноос зохион байгуулсан тэгш, жавхлант, жаргалант, дэлгэр, баян багийн ахмадын өдөрлөг болж "УЛААНБУРХАН" "АРТЕРИЙН ДАРАЛТ ИХСЭХ" өвчний мэдээ мэдээлэл сургалт хийж, бага эмч С. Улаанхүү эмчийг үзлэг хийж ажиллалаа. Үзлэгт нийт 5 багын 180 ахмад хамрагдлаа.



“MEASLES” УЛААНБУРХАН “КОРЬ”

НЭМ-ИЙН АЖИЛТАН
Б. СУМЬЯА



Артерийн даралт (АД) гэж юу вэ?

НЭМ-ИЙН АЖИЛТАН Б. СУМЬЯА





2.Ахмадын баярын цэнгүүд эрүүл мэндийн төвийн дарга О. Намхай мэндчилгээ дэвшүүлж, ахмадуудын дунд “ХЭН САЙН ЕРӨӨЛ ХЭЛЭХ ВЭ?” тэмцээн зохион байгуулж

Уран цэцэн үгээрэй бусдыгаа манлайнж 1-р байр Доржхуяг, 2-р байр Баасанжав нар шалгарлаа.



3. Эрүүл мэндийн төвд 22 жил няравын алба хашиж байгаад гавьяаныхаа амралтанд сууж байгаа Ж. Энхбат байгууллагын ажилчид хүндэтгэл үзүүлээ.



Эмнэлэгт ажилж байгаад гавьяаны амралтад гарсан ахмад ажилчдад хүндэтгэл үзүүлж гарын бэлэг өглөө.



4. Дэлхийн гар угаах өдөр 10-р сарын 15 2008 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас жил бүрийн аравдугаар сарын 15-ны өдрийг “Дэлхийн гар угаах өдөр” хэмээн тунхагласан. Гараа савандаж угаах нь нийт хүн ам, ялангуяа бага насны хүүхдийг суулгалт болон амьсгалын замын цочмог халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх энгийн, хүн бүрийн хийж чадах хялбар арга гэдгийг ойлгуулахад чиглэдэг.

Э. Түмэнжаргал багштай 2А анги, Э. Шинэтуяа багштай 4А анги, Д. Мөнхжаргал багштай 4Б анги, У. Туяацэцэг багштай дотуур байрны хүүхдүүдэл гарын ариун цэврийн талаар сургалт орлоо. Сургалтад нийт 104 хүүхэд хамрагдлаа.



Цэцэрлэгийн 4-5 настай 94 хүүхдүүдэд гар угаах талаар сургалт орсон .





5. ДОТООД СУРГАЛТ : Эмч эмнэлгийн ажилчдад “ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ЗӨВ ТАНИН ТОДРУУЛАХ ” журмын дагуу ахлах сувилагч Б. Гуацэцэг сургалт хийлээ. Сургалтад 22 эмч, эмчнэлгийн ажилчид хамрагдсан.



6. Эрүүл мэндийн газраас улирал бүр жирэмсэн эхчүүдэд жирэмсний үеийн аюултай шинж тэмдэг, жирэмсэн үеийн хоололт, жирэмсэн үеийн товлolt үзлэгийн талаар цахим сургалт ордог. 3-р улирлын цахим сургалт 9 дүгээр сарын 30нд нэг жирэмсэн цахимаар, танхимаар 3 жирэмсэн нийт жирэмсэн 4 ээж хамрагдсан.

